

1. SCHOOLING – СУРГУУЛЬ

<i>Vivien</i>	<i>Вивьен</i>
School in England usually starts at the age of five, but some children go to nursery school before that. I went to one for three days, when I was three, but I got really bored there and told my mum that I didn't want to go, so before I went to a real school she taught me at home. Some people send their children to a creche, where they're looked after during the day while their parents are out at work, but she got some books and taught me how to read and write, so when I went to school at the age of five, I had quite an advantage over the other children.	Англид гол төлөв таван настайдаа сургуульд суудаг. Зарим нь бүр өмнө асрах сургууль (бэлтгэл анги)-д сурдаг. Би гурван настай байхдаа нэг удаа бэлтгэл ангид гурван өдөр явсан. Гэвч, надад үнэхээр уйтгартай байсан учраас, дахиж явахгүй гэж ээждээ хэлсэн. Тэгээд жинхэнэ сургуульд явахаас өмнө ээж намайг гэрээр сургасан. Зарим аав ээж ажлын бүх цагт хүүхэд саатуулдаг өдрийн цэцэрлэгт хүүхдээ өгдөг. Харин, ээжид маань зарим нэг сурах бичиг, ном байсан бөгөөд түүгээр надад уншиж, бичихийг заасан тул би тавтай сургуульд орохдоо бусдаас нэлээд илүү сайн болсон байсан.
starts at the age of five - таван настайдаа сургуульд суудаг go to nursery school - асрах сургууль (бэлтгэл анги)-д сурдаг I got really bored -	
Anyway, my schooling really started when I was five, and from the age of five until I was nine, I went to a private school, which is quite unusual in England. It was an all - girls' school run by two old women, Miss and Ms McNamara. The standard was generally very high, and there were subjects like French, Maths and English Literature. I also took subjects like Ballet and Elocution, where we learnt how to speak correctly and we had to memorise and recite poems.	Гэлээ ч миний сурч боловсрох ажил таван наснаас л эхэлсэн. Би таваас есөн нас хүртлээ Англид нэлээд ховор байдаг хувийн сургуульд явсан. Энд зөвхөн охид сурдаг бөгөөд Макнамара овогтой, ганц бие, хоёр хижээл авгай сургуулийг удирддаг байлаа. Сургуулийн жишиг хөтөлбөр ерөнхийдөө хүнд байсан. Тэнд бид Франц хэл, Математик, Английн уран зохиол судалсан. Түүнээс гадна, би балет, илтгэх урлагийн хичээл сонгож, зөв ярих, шүлэг найраг цээжлэх, уран уншихыг сурсан.
Then my parents moved and I went to a village school, in the countryside. This was a primary school which children usually go to from the ages of five to eleven. And then, at eleven we took an exam called the eleven	Дараа нь аав ээж маань нүүснээр би хөдөө тосгоны сургуульд шилжсэн. Энэ сургууль бол гол төлөв таваас арван нэг насныхан сурдаг бага сургууль байв. Арван нэгтэйдээ бид "eleven plus" гэдэг анги

plus. If we passed that we could go to grammar school, and if we failed we had to go to secondary school, which wasn't usually of such good quality. I think the systems changed a bit now. Fortunately, I passed my eleven plus. There were all kinds of general knowledge questions and things that, basically, you can work out if you've got any common sense.	дэвших шалгалт өгнө. Сайн шалгуулбал хэлзүйн (grammar school) сургуульд орно. Тааруухан шалгуулбал дунд сургуульд орно. Энэ сургуулийн сургалт тийм ч сайн байгаагүй. Одоо энэ тогтолцоо жаахан өөрчлөсөн байх гэж бодож байна. Аз болоход би “eleven plus” анги дэвших шалгалтад тэнцсэн. Тэнд үндсэндээ ерөнхий мэдлэг шалгасан асуулт болон хэвийн мэдрэмж, ухамсраар хариулж болох төрөл бүрийн юм байсан.
--	--

<p>School – Сургууль in England – Англид usually – Голдуу starts – эхэлдэг at the age – настайд of – ын, ийн, аар⁴, тай³, ч five – таван but - гэвч some – зарим children – хүүхэд go to – явдаг to – руу, рүү, хүртэл, д, т nursery - асрах school – сургууль before - өмнө that – тэр (түүнээс) I – Би went to – явсан one – нэг удаа for – д, т three – гурван days - өдөр when – хэзээ was – байсан really - үнэхээр got - байсан bored - уйтгартай there – тэнд and – тэгээд told – хэлсэн my – миний mum – ээж didn't - үгүй байна want – маар⁴ to go – явах so – тэгээд real – жинхэнэ she – тэр(эмэгтэй) taught – сургасан, заасан me – намайг at home – гэрт people – хүн send - явуулдаг their – тэдний a creche - өдрийн цэцэрлэг where – хаана they're – тэд байдаг looked – хардаг after – дараа during – турш the day - өдөр while - зуур parents – аав ээж are - байх out – явах, гарах at – д work - ажил books - ном how – яаж to read – унших write – бичих had – байсан quite – нэлээд an advantage – сайн, давуу over – илүү other – бусад</p>	
<p>Үгчилсэн орчуулга</p> <p>Anyway – юутай ч, гэлээ ч from – аас⁴ until – хүртэл, болтол nine – ес private – хувийн which – аль, ямар is – байдаг unusual – ховор It – тэр all – бүх, зөвхөн, girls' - охидын run – удирдах by - аар⁴ two – хоёр old – настай women - эмэгтэй Miss – авхай Ms - гуай, хатагтай standard - жишиг generally – ерөнхийдөө very – маш high - чанга, хатуу were – байсан subjects – хичээл like – гэх мэт, гэх зэрэг French – Франц хэл Maths – математик English – англи хэл, англи Literature – уранзохиол also – бас took - үзэх, авах, шалгуулах Ballet – балет, бүжгийн жүжиг Elocution – илтгэх урлаг we – бид learnt – сурсан how – яаж to speak - ярих correctly – зөв had – байсан to memorise - цээжлэх recite – цээжээр унших poems – яруу найраг, шүлэг</p>	
<p>Үгчилсэн орчуулга</p> <p>Then – дараа нь, тэгээд moved – нүүх, шилжих a village – тосгон countryside – хөдөө</p>	

<p>This – энэ a primary - бара eleven - 11 exam – шалгалт called – гэдэг plus - нэмэх. If – хэрэв, бал⁴, вал⁴ passed – давах, өнгөрөөх could - чадна grammar – хэлзүй failed – унах secondary – хоёрдугаар, дунд wasn't – байгаагүй such – тийм quality - чанар think – бодох system`s – тогтолцоо changed - өөрчлөгдсөн a bit - жаахан now - одоо Fortunately - азаар kinds – зүйл, юм knowledge - мэдлэг questions - асуулт things - юмс basically – гол, үндсэн you – та can - чадах you've got – та байх any – ямар нэгэн common – энгийн, ердийн sense – мэдрэмж, ухамсар, ухаан</p>	
<p>Then I went to a grammar school. This was an all - girls' school as well, and it was called "Bishop Foxes". There was also an equivalent, all - boys' grammar school on the other side of town. So they kept us apart. That was also quite a good school. It was good for languages. So from the age of eleven until say sixteen when we took our "0" levels, which were "Ordinary" level exams, we studied about, maybe, nine subjects. First of all we had English Language and English Literature, History, Geography, Biology, Physics, Chemistry, and Art, and then other subjects like Cooking (they called it Domestic Science) and Technology (just woodwork in fact) which wasn't very popular, it being an all - girls' school. There was also French, and then another language - I studied Russian. You could choose from Russian, Spanish, Latin, or German.</p>	<p>Дараа нь би "Бишоп фоксиз" нэртэй хэлзүйн сургуульд орсон. Энэ бас л охидын сургууль байсан. Хотын нөгөө захад яг ийм хэлзүйн сургууль байсан бөгөөд тэнд зөвхөн хөвгүүд сурна. Биднийг ийнхүү тусгаар байлгадаг байв. Тэр маш сайн сургууль байсан. Энд хэл сайн заадаг. Бид арван нэгээс арван зургаан нас хүрч, энгийн төвшний "0" шалгалт өгөхдөө ерөнхий эрдмийн есөн хичээл үзчихсэн байлаа. Эн тэргүүнд англи хэл, утга зохиол, түүх, газарзүй, биологи, физик, хими, зургийн хичээл үзсэн. Мөн хоол хийх арга /гэр ахуй гэж нэрлэдэг/, технологийн /зөвхөн модон эдлэл хийх/ зэрэг хичээл үзсэн. Технологийн хичээл охидын сургуульд олигтой болж чадаагүй. Түүнчлэн, тэнд франц хэл болон бусад хэл заадаг. Орос, испани, латин, герман хэлнээс аль нэгийг сонгох боломжтой байсан. Би орос хэл сонгосон.</p>
<p>My favourite teacher was in fact my Russian teacher. She was French teacher who was married to a very old Russian emigri. I was only one studying Russian, so every one call me "Vivien the communist", but it was good because it meant I had private classes. However, this made it more demanding because I always had to do my homework and there was no excuse.</p>	<p>Миний хамгийн хайртай багш бол орос хэлний багш. Тэр Орос Улсаас цагаачлан ирсэн ахимаг эртэй гэрлэсэн франц багш байсан юм. Би ганцаараа орос хэл сонгосон учраас хүн бүр шахам намайг "коммунист Вивьен" гэдэг байж билээ. Ингэж сонгосон явдал надад сайн юм болсон. Яагаад гэвэл, би өөрийн хувийн багштай болчихсон хэрэг. Гэхдээ гэрийн</p>

	даалгавар дандаа хийхээс өөрөөр хаашаа ч зайлах аргагүй болсон гээд хариуцлага шаардлага их болсон.
<p>I had some other very good teachers, but I've noticed that teachers are really different in Hungary. In England they're not nearly as tactile, or affectionate with the students. They're very formal and quite strict. When I was sixteen, we went on an exchange trip to the States for a month. We went to a high school in Massachusetts, and it was interesting. In fact, it was quite an eye - opener. It was quite amazing for me really, as there were signs all around saying things like "No guns" and "No drugs", and it was quite violent. Also, I noticed that the students didn't have any respect for the teachers and would just shout at them, and coming from a strict school that was quite a shock. They would shout back at the teachers, call them names and hurl abuse at them, and they rarely listened to anything the teacher said. They weren't very interested in learning.</p>	<p>Би өөр олон сайн багштай байсан. Гэвч, тэд Мажарын багш нараас шал өөр гэдгийг би мэдсэн. Англид багш нар сурагчтайгаа тийм ч найрсаг дотно бус, маш албархаг, ширүүн харилцдаг. Арван зургаан настайдаа би АНУ руу солилцооны аялалаар сарын хугацаатай явсан. Бид Массачусетц мужийн нэгэн ахлах сургуульд очсон. Ёстой л нүд бүлтийлгэсэн аялал байсан. Энд тэндгүй л “Буутай явахыг хориглоно”, “Хар тамхи татахыг хориглоно” гэсэн хуудас наасныг харахад надад хачин санагдсан. Тэр үе бол буу зэвсэг, хар тамхины хэрэг ид цэцэглэж байсан цаг л даа. Түүнчлэн, сурагчид нь багш нараа үл хүндэтгэдэг, тэдэнтэй ярихдаа дуугаа өндөрсгөдөг болохыг анзаарсан. Хатуу дэглэмтэй сургуулиас ирсэн миний хувьд энэ маш хачин санагдаж байв. Сурагчид багш руугаа хашгичиж, нэр хоч өгч, тэр ч бүү хэл доромжилж, хэлсэн ярьсныг нь үл тоомсорлох энүүхэнд. Тэд тийм ч сурах сонирхолтой биш шиг санагдсан.</p>
<p>So, at the age of sixteen we took "0" level exams, and then some people left after that. That was one option, or we could go on to a technical college or "Tech", and maybe study some kind of vocational subject like nursing, or some kind of technical or computer studies, or we could stay on for another two years, as I did, and take "A" levels, which are Advanced level exams. I took "A" levels in English Literature, Russian and Spanish, which, in retrospect, wasn't a very good idea, because I</p>	<p>За тэгээд, арван зургаан настайдаа бид “О” төвшний шалгалт өгсөн, үүний дараа зарим маань сургуулиас гарсан. Бид “Тех” гэж нэрлэдэг техникийн сургууль, мөн сувилагчийн курс, эсвэл, ямар нэгэн техник мэргэжлийн сургууль, компьютерчийн сургууль сонгож болно. Эсвэл миний сонгосонтой адил сургуульдаа бусад мэргэжлээр дахин хоёр жил сурахаар үлдэж болно. Дараа нь дэвших “А” төвшний (“Адвансэд” -</p>

<p>had to read so many books. I had to sit and read Tolstoy, Dickens and Cervantes.</p>	<p>ахисан, дээд зэрэглэлийн) шалгалт өгдөг. Би “А” төвшинд английн уран зохиол, орос хэл, испани хэлний шалгалт өгсөн. Толстой, Диккенс, Сервантис гээд л зөндөө юм уншсан энэ сонголт эргээд бодоход тийм ч ухаалаг санаа биш байжээ.</p>
<p>At the age of about eighteen, in August, everybody in my year was waiting for their "A" level results to see if they got high enough grades to go on to university. We had to apply for five universities, which we put on a list, with the best one at the top. If you want to go to Oxford or Cambridge, of course, you have to put that as number one, and then it goes down, so Oxford and Cambridge would have to be first, and then maybe Bristol, Manchester, Leeds and the rest. The Scottish universities are very good. The universities require a certain grade - 'A' to 'C' are passes. 'A' is the best, followed by 'B', then 'C'. Usually, they ask for three 'C's or above.</p>	<p>Миний үе тэнгийнхэн буюу арван наймтууд их сургуульд элсэхэд хүрэлцэх оноо авсан эсэхээ мэдэх гэж, найман сард “А” төвшний шалгалтын дүн гарахыг хүлээнэ. Бид таван их сургуулиас сонгох эрхтэй, тэднийг элсэхийг хамгийн их хүсч буй дарааллаар жагсааж бичдэг. Хэрвээ, Оксфорд, Кембриджийн сургуульд орохыг хүсч байвал мэдээж эхэнд бичин, бусдыг араас нь жагсаана. Оксфорд, Кембридж гээд, дараа нь магадгүй Бристол, Манчестер, Лидс гэх мэтээр жагсаасан байж болно. Шотландын их сургуулиуд их сайн. Их сургууль “А”-ээс “С” хүртэлх тодорхой зэрэглэл шаарддаг. “А” нь хамгийн сайн, түүний дараагаар “В”, “С” орно. Их сургууль ер нь гурван “С” болон түүнээс дээш байхыг шаарддаг.</p>
<p>I passed, fortunately, and I went to Leeds University, which was my first choice because it had a very good Russian department, and I studied Russian and Spanish. University usually lasts for three or four years. We were lucky, as when I was at university we were given a grant, or a lump sum of money to live on, and we didn't have to pay it back. The amount you got was graded according to your parents' income. So, if your parents didn't have very much money you got a full grant, which</p>	<p>Аз болоход би шалгалтад тэнцэж Лидсийн их сургуульд орсон. Энэ сургууль үнэхээр сайн Орос судлалын тэнхимтэй байсан учраас би эхлээд түүнийг сонгосон юм. Тэнд би орос, испани хэл үзсэн. Их сургууль ихэвчлэн гурав юм уу, дөрвөн жил байдаг. Бид их сургуульд ороод, буцааж төлөхгүй тэтгэлэг авсан их азтай улс. Энэхүү тэтгэлэгийн хэмжээ аав ээжийн орлогын төвшнөөс шалтгаалдаг. Хэрэв аав ээж</p>

<p>was not a lot of money, but you could live on it. So you could pay your rent, get food and go out quite a lot, as well as buy your books. Going to live in Leeds in the North was better, because things were much cheaper than, say, if I had been in London, where I imagine it's very difficult for a student to survive, especially these days.</p>	<p>тань тийм ч чинээлэг биш бол бүрэн тэтгэлэг авна. Энэ нь тийм ч их мөнгө биш ч гэсэн, амин зуулганд нэмэртэй. Өрөөнийхөө хөлсийг төлөх, хооллож ундлах, зугаалж цэнгэх, ном авахад хангалттай. Оюутан хүнд хэцүү бэрх, амьжиргааны өртөг ихтэй Лондонд, ялангуяа, өнөө үед сурснаас Хойд нутгийн Лидсийн сургуульд явсан нь дээр гэж бодогдсон.</p>
<p>At university, it's quite different from being at school because you have to rely on your own motivation. I know a lot of people who just didn't go to any of their classes because they weren't compulsory.</p>	<p>Их сургууль дунд сургуулиас шал өөр. Өөрөө өөрийгөө авч явна. Заавал үзэх ёстой биш л бол олон хүн хичээлдээ очихгүй байхыг би харсан.</p>
<p>It was three years of enjoying yourself, basically, studying what you wanted to study, being away from home for the first time, and having some money and being able to go out to parties and concerts. For the first year, I lived in a hall of residence, which was a bit like being in a boarding school. There were lots of eighteen - year olds away from home for the first time, and of course they couldn't cook, and they weren't used to doing their own washing or looking after themselves. It kind of eased you into living on your own. So this was good, because we had to learn to look after ourselves, cooking and cleaning, and at the same time finding time to study for our finals. Final exams at university were based on the whole three years' studies, so there was a lot to learn and it was quite stressful in July when exam time came round. Some people think that this is not a good idea, and that maybe it would be better if there was some sort of system of continuous assessment, because there are a lot of people who do very well all year, and work</p>	<p>Энэ бол гэрээсээ анх удаа хол байж, юу хүссэнээ сурч мэдсэн, өөрийн гэх мөнгөтэй байж, үдэшлэг болон концертод явах бүрэн боломжтой, баяр хөөртэй гурван жил байлаа. Эхний жил би нийтийн байранд суусан. Энэ маань сургуулийн дотуур байранд байсантай бага зэрэг төстэй. Тэнд анх удаа гэрээсээ хол яваа 18 - тууд олон байсан. Мэдээж, тэд унд хоол хийж, угааж арчиж, хувцас хунараа тохируулан өмсөж чаддаггүй байсан. Энэ бүхэн бие даасан амьдралд амархан сурч дадахад тустай, сайн хэрэг байв. Бид биеэ аваад явахтайгаа болж, хоол унд хийж, угааж цэвэрлэж сурсны дээр сургууль төгсгөх шалгалтандаа бэлтгэх зав гаргаж дөнгөдөг болсон байлаа. Гурван жилийн турш үзэж судалсан хичээлээр их сургууль төгсгөх шалгалт авна. Тиймээс, маш их уншиж давтах хэрэгтэй болдог бөгөөд ялангуяа долдугаар сард шалгалт дөхөөд ирэхлээр ажил маш их болдог байсан.</p>

<p>very hard, but when it comes to doing exams they just go crazy with stress and can't remember anything when it comes to the three hour exam you have to do. So, I would be more in favour of that because I don't think three hours can fairly represent however much you have learnt in three years.</p>	<p>Зарим хүн үүнийг буруу тогтолцоо гэж үздэг. Тэгээд, магадгүй, үүний оронд явцын тасралтгүй үнэлгээний тогтолцоо илүү дээр байх байсан болов уу гэдэг. Учир нь, бүх л жилийн туршид үнэхээр сайн суралцаж, шургуу хичээллэж байсан ихэнх оюутан шалгалтын үеийн ажлын дарамтаас болж ядаргаанд ороод, төгсгөх шалгалт хэмээх гуравхан цагийн дотор юу ч санаж чадахгүйд хүрдэг. Гурван жил ихийг сурч мэдсэн ч түүнийгээ гуравхан цагийн дотор шударгаар дүгнүүлж чадахгүй гэж боддог учраас би санал нэгтэй байдаг.</p>
<p><i>Thomas</i></p>	<p><i>Томас</i></p>
<p>Hi, my name is Thomas. I'm from Leicestershire in England, a small village near Leicester called Glenfield to be exact. I was born there, and have lived there for most of my life. When I was very young, my mother always used to stay at home with me and teach me things, and play with me. I never had to go to a creche because she didn't have to work. My father always came home at about 6 o'clock at night after a long day at work, and he worked enough that my mother didn't have to. So this was great. My first real contact with other children was when my brother was born, when I was 3. And after that, at the nursery school. I only remember a few things about the nursery school because I was only 5 or 6, but I do remember a lot of bright colours, and that there were a lot of things to do. There was painting equipment, things to put on top of each other like bricks to build little houses out of, and a lot of children... I remember that we didn't have to do very much there. It wasn't like my later memories of school, when it became</p>	<p>Сайн байна уу? Намайг Томас гэдэг. Би Английн Лейсестерширийнх. Чухамдаа бол Лейсестрээс холгүй орших Гленфилд тосгоных. Би тэнд төрж, ихэнх насаа тэнд өнгөрүүлсэн. Намайг бүр бага байхад ээж минь үргэлж надтай хамт гэртээ байж, тоглож, юм хум зааж сургадаг байж билээ. Ээж маань ажил хийдэггүй байсан учраас би нэг ч удаа хүүхдийн цэцэрлэгт яваагүй. Аав минь өдөржин ажиллаад орой бүр 6 цагийн үед гэртээ ирдэг байсан. Тэр ээжийг ажил хийлгэхгүйн тулд их ажилладаг байсан юм. Мундаг шүү. Намайг 3 настай байхад миний дүү төрснөөр би анх удаа бусад хүүхэдтэй харилцсан билээ. Түүний дараа сургуулийн өмнөх бэлтгэл анги орно. Би дөнгөж 5 – 6 настай байсан болохлоороо сургуулийн өмнөх бэлтгэл ангийн талаар бага юм санадаг. Гэхдээ, би тод өнгийн олон тоглоом, мөн хичээлийн хэрэгслийг санадаг. Тэнд мөн будгийн хэрэгсэл,</p>

<p>much more difficult and demanding.</p>	<p>жигжиг байшин барьж байгаа мэт дээр дээр нь өрж тавьдаг шоо, олон хүүхэд байсан. Тэнд их зүйл хийх шаардлагагүй байсныг би санаж байна. Энэ бол илүү хэцүү болж, ихийг шаардах болсон сургуулийн дурсамжаас их өөр.</p>
<p>My first impressions of primary school were very, very different to what I was used to before. I think I cried, like many children on their first day. I wasn't so happy about being without my mother for more than 2 or 3 hours. However, I soon got used to it, and found lots of interesting places to hide and play in the school playground. I remember that there were many things to climb and swing on. We learned pretty much the same as children everywhere, I suppose. We learned the basics of Maths and English, and we started to do sport.</p>	<p>Бага сургуулийн анхны сэтгэгдэл түрүү үеийнхээс их өөр байсан. Би анхны өдөр бусад хүүхдийн адил уйлсан. Миний хажууд ээж минь 2 - 3 цагаар байхгүй байгаа нь гунигтай байлаа. Гэсэн ч, удалгүй би үүнд дасч сургуулийн тоглоомын талбайгаас ганцаараа суух, тоглох олон аятайхан газар олсон. Тэнд авирч гарах, дүүжигнэж тоглох олон юм байсныг санаж байна. Бид бусад хүүхэдтэй бараг адил зүйл сурсан гэж боддог. Бид математик, англи хэлний ерөнхий эрдмийн хичээл судалсан, мөн биеийн тамираар хичээллэж эхэлсэн.</p>
<p>I remember at playtime, which was at about 10 o'clock in the morning, and then at another break at dinner time at about 12 o'clock, that we used to play a lot of sport as well. But my strongest memories of it were of very rough games. I suppose that those experiences which really stay with you are the strongest ones. I remember a few times being hit during a game of football, and I wasn't very happy about it!</p>	<p>Би тоглоомын цагийг санаж байна. Тоглоомын цаг өглөөний 10 цагийн үед, мөн бусад завсарлагааны цаг, цайн цаг, тэгээд 12 цагийн үед тохионо. Бид төрөл бүрийн сайхан спорт тоглоомоор тоглодог байсан. Гэвч, энэ бол надад мартагдашгүй сэтгэгдэл төрүүлсэн маш хэцүү тоглоом байсан. Энэ явдал танд тохиолдсон бол мөн л хэцүү тоглоом гэж бодогдох байсан болов уу. Би хөл бөмбөг тоглож байхдаа өшиглүүлснээ хэзээ ч мартахгүй. Түүнийг дурсахлаар үнэхээр маш дур гутдаг.</p>
<p>I also remember being taken to the head master for calling another child a bad name. However, I generally got on quite well with the teachers, I was quite successful in class, and even though I found it a struggle, I don't think it was as much</p>	<p>Түүнчлэн, би хүүхдэд нэр хоч өгөөд захирлын өрөөнд дуудагдаж байснаа санадаг. Гэхдээ, би дажгүй сурсан, багш нар ч надад ам сайтай байсан, сургуулийн амьдрал надад тэмцэл мэт</p>

of a struggle for me as it was for a lot of the other children around me.	санагдсан ч сурна гэдэг манай ангийн бусад хүүхдийг бодвол, надад тийм ч хэцүү байгаагүй.
I remember a few of the teachers very well. I remember Mrs. Jenkins, who taught us for the first year. Her classroom was so nice - there were models of dinosaurs and pictures of dinosaurs on the walls. This fired me up with a great enthusiasm for dinosaurs which lasted for a couple of years after that. I even remember that in the school assembly, which used to happen every morning before lessons started, one day I was called to speak about dinosaurs and to tell the other children about my interest in them. Looking back on it now, it probably would have been quite embarrassing to see myself then, but at that time I was very excited about it and very proud.	Би зарим багшаа тод санадаг. Тухайлбал, анхны жил хичээл засан Женкинс багш байна. Түүний анги их сайхан байсан. Тэнд үлэг гүрвэлийн загвар өрөөстэй, бас хананд нь үлэг гүрвэлийн зураг байж билээ. Тэр бүхэн үлэг гүрвэл сонирхох сонирхлыг минь бадраасан бөгөөд тэр сонирхол хоёр жилийн турш бадарсан юм. Өглөө бүр хичээл эхлэхээс өмнө болдог байсан сургуулийн чуулган дээр би нэг өдөр өөрийнхөө сонирхдог юм буюу үлэг гүрвэлийн талаар бусад хүүхдэд ярьснаа санаж байна. Тэгэхэд миний сэтгэл маш их хөдөлсөн, бас омогшсон байж билээ. Энэ бүхнийг одоо эргэн санахад ичмээр байна.
Primary school lasted for two years, after which came junior school, which I think lasted for four years. Each year we had a different teacher and that teacher would teach us all of the different subjects. For the first time, our time became divided into subjects, so every Wednesday morning we would study Mathematics, every Tuesday afternoon we would study English, and so on.	Бага сургуульд хоёр жил суусан. Тэгээд “жүниор” гэж нэрлэдэг сургууль эхэлсэн. Энэ сургууль дөрвөн жил үргэлжилсэн шиг санагдаж байна. Жил бүр бид өөр багштай байж, тэдгээр багш төрөл бүрийн өөр хичээл заадаг байв. Хоёрдахь өдрийн үдээс хойш англи хэл, гуравдахийн өглөө тооны ухаан гэх мэтээр нэгдүгээр цаг дээр бидний хичээлийн хуваарийг гаргасан.
I was quite a good student really. I didn't have too many problems with the work, but I used to get into quite a lot of trouble for talking, especially when I spoke at the same time as the teacher.	Би үнэхээр сайн сурагч байжээ. Хичээл сурлагын талаар бэрхшээл гардаггүй байсан. Гэвч, их яриагаасаа болоод үргэлж эвгүй байдалд ордог байсан. Ялангуяа багштай уралдаж яриад баларна.
We had an Indian teacher called Mr. Salwan, who was a Hindu, I'd never met a Hindu before, and he was the first person I knew who	Бидэнд Салван гэдэг энэтхэг багш хичээл ордог байсан. Тэр хиндү үндэстэн. Би урьд нь хэзээ ч хиндү

<p>was a vegetarian. After meeting him again, a few years later, I became a vegetarian, and have been for 10 years now. So I suppose he made quite a strong impression on me.</p>	<p>хүнтэй таарч байгаагүй, тэр бас миний мэдэх анхны цагаан хоолтон хүн байсан. Түүнтэй анх тааралдсанаас хойш хэдэн жил болоод дахин тааралдахдаа би цагаан хоолтон болсон байсан. Би одоо бол цагаан хоолтон болоод 10 жилийн нүүр үзжээ. Тэр намайг маш их өөрчлөгдөхөд хүргэсэн хүн дээ.</p>
<p>My memories of playtime were that it was even rougher than at primary school. I think that a lot of the time I used to play with the girls, because playing with the boys was just too violent. Sometimes, I did enjoy playing superheroes or soldiers with the other boys. Most of the children played sports at playtime, but I remember that I never really enjoyed it, as I was never really good at them.</p>	<p>Тоглоом бага ангид байснаас улам хатуу болсон шиг санагддаг. Би ихэнхдээ охидтой тоглодог байсан. Учир нь хөвгүүд тоглоход хэтэрхий зэрлэг догшин санагддаг байсан. Заримдаа бусад хөвгүүдтэй шилдэг баатар, эсвэл цэрэг болж тоглоход зүгээр байсан. Ихэнх хүүхэд тоглоомын цагаар спорт тоглоомоор тоглож байхад, би бол тийм юманд үнэхээр дуртай биш, тэгээд ч авьяасгүй байсан.</p>
<p>High school and secondary school were a bit of a different story from the earlier schools. I think they seemed to take themselves a lot more seriously. The subjects were all examined, and at the end of the school we were given grades, which we carry with us through our lives. I came out of secondary school with quite good grades. I really did work hard for them. I remember that a lot of my studying was really last minute, though... I used to wait until two weeks before the exam, and then study all day, every day, sometimes, in the days coming up to the exams, without even sleeping. On the doorstep of the exam room, I'd be reading my revision notes. However, this technique of passing examinations worked for me. It does mean, however, that now I remember very little of what I learned at school.</p>	<p>Дунд болон дээд сургууль анхан шатны сургуулиас бага зэрэг ялгаатай байсан. Дунд сургуульд илүү бие дааж хичээллэх шаардлагатай болсон юм шиг надад санагддаг. Бүх хичээлээр шалгалт авдаг, мөн сургуулийн төгсгөлд, насан турш дагаж явах зэрэглэл олгодог. Би дунд сургуулиа маш сайн зэрэглэлтэй төгсгөсөн. Би үүний төлөө маш шургуу хичээллэж байсан. Минут болгоныг шамдан сурч өнгөрөөсөн . . . Би шалгалт эхлэхээс хоёр долоо хоногийн өмнөөс өдөр бүр, өдөржин, шалгалт дөхсөн үед заримдаа нойргүй хонон давтдаг байлаа. Шалгалт авч буй өрөөний хаалганд тулж очоод байхдаа ч би шалгалтын асуултаа уншиж байсан. Шалгалт өгөх ийм арга ямар ч гэсэн тус болж байсан. Гэхдээ л сургуульд сурсан зүйлээс одоо миний</p>

	санаанд маш бага юм үлджээ.
<p>The last years of secondary school were really oriented towards getting people on to university, and starting them on their careers. I remember we spent a lot of time in careers training, filling in questionnaires to decide whether we could become hairdressers, or road - maintenance vehicle operators. I spent most of my time in the music department. I'd been learning the clarinet from the age of about nine, and this was a very strong interest for me. I used to manage to get out of some of my sports lessons by taking extra music practice. I liked my clarinet teacher very much. He had a strong influence on my music later on in life, as he taught me the basics of it. I didn't get on with my general music teacher so well, which is why I didn't continue music studies to "A" level. In England, we have "O" levels at the age of 15 or 16, and "A" levels at the age of 17 or 18. If you get really good grades at "A" level, you can go on to university. But if you don't obtain these, then you have to look out into the big wide world, and try to find somebody who will employ you, and give you a start in your career.</p>	<p>Дунд сургуулийн сүүлчийн жилүүд биднийг их сургуульд бэлтгэхэд чиглэдэг бөгөөд ажил мэргэжил сонгуулж эхэлдэг. Бид үсчин, эсвэл зам засварын машины жолооч болох эсэхээ шийдэх гэж асуулга бөглөхөөс эхлээд, мэргэжлээ сонгох гэж ихээхэн цаг үрсэн санагдана. Би өөрийнхөө ихэнх цагийг хөгжмийн ангид өнгөрүүлсэн. Би есөн настайгаасаа бишгүүр хөгжим тоглож сурсан. Би үүнийг маш их сонирхож байсан. Сайн хөгжимдөж сурахын тулд биеийн тамирын зарим хичээлээсээ гарахаар оролдож байлаа. Би бишгүүр хөгжмийн багшдаа их хайртай. Тэр надад хөгжмийн анхан шатны үндсийг заан өгч сайн хөгжмийн мэдрэмжтэй болгосон. Би хөгжмийн ерөнхий багштайгаа олигтой таардаггүй байсан. Тэгээд л би “А” дүн авч чадаагүй юм. Англид бид 15 - 16 насандаа “O” төвшин, 17 - 18 насандаа “A” төвшний зэрэглэл авна. Үнэхээр “A” төвшний сайн зэрэглэл авбал их сургуульд орж болно. Авч чадахгүй бол ажилд оруулж, мэргэжлээрээ ажиллах боломж олгох хүнийг хайж, дэвэн дэлхийд нүд бэлчээх хэрэгтэй болно.</p>
<p>I was lucky to get good grades at "A" level, so I went on to university. In the end, I decided to study biology as I'd been very successful in science subjects. But when I finally got to university, I found that Sheffield (which was the city where I was studying) was a much bigger, smellier, noisier city than I was used to, and I couldn't cope with it for more than a year. Also, I really realised that I didn't want to be a</p>	<p>Азаар би “А” төвшний зэрэглэл авч, их сургуульд орсон. Эцсийн эцэст би байгалийн ухааны хичээлд үнэхээр сайн байсан болохлоороо биологид суралцахаар шийдсэн. Ингээд их их сургуульд ордог дээрээ тулахад Шеффилд (миний сурч байсан газар) хот урьд байсан газраас минь их том, бохир агаартай, дуу чимээ ихтэй нь мэдэгдлээ.</p>

<p>scientist, and I couldn't see the reason for filling my head with facts and figures, useless information, which I couldn't relate to my practical life around me, so I spent most of my time with friends, sitting and listening to music, and discussing philosophy and life.</p>	<p>Тэнд би жилээс илүү тэсч чадаагүй. Тэгээд ч би эрдэмтэн болох дургүй байгаагаа мэдсэн. Мөн, ердийн аж амьдралд тус болохгүй тоо баримт, хэрэггүй мэдээллээр толгойгоо дүүргэх ямар шаардлага байгааг мэдэхгүй байсан. Тиймээс, би ихэнх цагаа найзуудтайгаа хамт сууж, хөгжим сонсож, гүн ухаан, аж амьдралын талаар ярилцаж өнгөрүүлдэг болсон.</p>
<p>After failing my first year exams at university, I moved away to Glastonbury, a small town in the south, with many artists and musicians, where I could find a lot of things to do which really did inspire me. But this was much to my family's disapproval.</p>	<p>Их сургуулийн эхний жилийн шалгалтанд унасныхаа дараа, би олон жүжигчин, хөгжимчинтэй өмнө зүгийн жижиг хот Гластонбери рүү шилжсэн. Тэндээс би миний урам зоригийг бадраасан олон юм олсон. Гэвч, манайхан үүнд минь дургүй байсан.</p>